

2013

танаа

Оны
эхний
4 сар

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

/албан ёсны статистикийн мэдээллээр бэлтгэсэн танилцуулга/

**ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Хүснэгт 1. Жил бүрийн эхний 4 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Суурин хүн ам	Тоо	25931	25877	25875	26905	27036	27440	
Шинээр төрсөн хүүхэд	Тоо	60	260	245	218	199	220	272
Нас баралт	Тоо	62	72	56	53	59	49	62
Шилжиж ирсэн	Тоо	278	374	307	503	252	304	461
Шилжиж явсан	Тоо	256	571	474	543	253	377	447
Ажилгүйчүүд	Тоо	441	304	498	751	585	498	374
Халдварт өвчин	Тоо	222	252	221	168	204	186	229
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	90	118	99	97	86	108	99

ТӨСӨВ, САНХҮҮ 2013 оны эхний 4 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого 214.3 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 79.8 сая төгрөгөөр буюу 27.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Орон нутгийн төсвийн орлого

мянган төгрөг

Үзүүлэлт	2012 он	2013 он	Өсөлт бууралт	Хувь
Орлогын албан татвар	42744.2	42206.0	-538.2	98.7
Өмчийн татвар	592.3	523.0	-69.3	88.3
Бусад татвар	177263.7	87767.2	-89496.5	49.5
Хүү торгуулийн орлого	24617.5	12622.1	-11995.4	51.3
Бусад нэр заагдаагүй орлого	23752.2	21678.4	-2073.8	91.3
Хөрөнгө худалдсаны орлого	25153.2	49520.2	24367.0	196.9
Татварын орлогын дүн	294123.1	214316.9	-79806.2	72.9



Орон нутгийн татварын орлогын 41.0 хувь буюу 87.8 сая төгрөгийг бусад татвар бүрдүүлж байгаа бөгөөд уг орлогыг улсын тэмдэгтийн хураамжийн 17.1 сая төгрөг, хог хаягдлын хураамж 25.1 сая төгрөг, усны төлбөр 45.5 сая төгрөгөөр тус тус бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын өөрийн орлогод 32.9 сая төгрөг төвлөрч, нийслэлээс 3609.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч ажилласан байна.

Хүснэгт 3. Орон нутгийн төсвийн зарлага

мянган төгрөг

Үзүүлэлт	2012 он	2013 он	Өсөлт бууралт	Хувь
Цалин хөлс	195155.4	281849.2	86693.8	144.4
Нийгмийн даатгалын шимтгэл	15740.2	23786.1	8045.9	151.1
Бараа үйлчилгээний бусад зардал	321419.8	351940.3	30520.5	109.5
Татаас ба урсгал шилжүүлэг	7140.9	1733.0	-5407.9	24.3
Хөрөнгийн зардал	72545.0	-	-	-
Нийт зарлагын дүн	612001.3	659308.6	47307.3	107.7

2013 оны эхний 4 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт зарлага 1208.1 сая төгрөг болсон бөгөөд үүнээс 548.8 сая төгрөгөөр нийгмийн халамжийн зардлыг санхүүжүүлж, орон нутгийн төсвийн гүйцэтгэл 659.3 сая төгрөг болсон байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 47.3 сая төгрөг буюу 7.7 хувиар өссөн байна.

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 42.7 хувийг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 3.6 хувийг, бараа үйлчилгээний бусад зардал 53.4 хувийг, татаас ба урсгал шилжүүлэг нийт зардлын 0.3 хувийг тус тус эзэлж байна.



Хүснэгт 4. Орон нутгийн төсвийн өглөг, авлага

	Сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн	Барагдуулсан	Сарын эцсийн үлдэгдэл
Өглөг	78031.1	7340.5	5539.7	79831.9
Авлага	5626.3	9534.7	3169.8	11991.2

Орон нутгийн төсвийн өглөг тайлант хугацааны эхэнд 78.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант хугацаанд 7.3 сая төгрөгийн өглөг үүсч, 5.5 сая төгрөгийн

өглөг барагдуулж, тайлант хугацааны эцэст 79.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Орон нутгийн төсвийн авлага 12.0 сая төгрөг байна.


АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 2013 оны эхний 4 сарын байдлаар 31.8 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 7.6 хувиар буюу 2.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт


Үзүүлэлт	Нийт үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/			Нийт үйлдвэрлэлт /үнийн дүнгээр, мянган төгрөг/		
	2012 он	2013 он	өсөлт бууралт	2012 он	2013 он	өсөлт бууралт
Нүүрс олборлолт /мян.тн/	1340.8	1468.3	127.5	27486400.0	30100150.0	2613750.0
Дулаан дамжуулалт /мян.гкал/	92.6	81.0	-11.6	1662511.4	1557841.2	-104670.2
Талх үйлдвэрлэлт /тонн/	17.7	21.7	4.0	21646.7	27266.3	5619.6
Нарийн боов үйлдвэрлэлт /тонн/	24.4	36.6	12.2	63481.0	91789.0	28308.0
Арматур үйлдвэрлэлт /тонн/	350.0	-	-350.0	297500.0	-	-297500.0

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг /биет хэмжээгээр/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 9.5 хувиар буюу 127.5 мянган тонноор, нарийн боов үйлдвэрлэлт 80 хувиар буюу 12.2 тонноор, талх үйлдвэрлэлт 22.6 хувиар буюу 4.0 тонноор тус тус өссөн бол, дулаан дамжуулалт 12.5 хувиар буюу 11.6 мянган гкал-аар буурсан байна. Тайлант хугацаанд барилгын арматур үйлдвэрлэгдээгүй байна.

Зураг 3. Нүүрс олборлолт /мян.тонн/



Зураг 4. Нүүрс олборлолт /сараар/




Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг үнийн дүнгээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд нүүрс олборлолт 9.5 хувиар буюу 2613.7 сая төгрөгөөр, нарийн боов үйлдвэрлэлт 44.6 хувиар буюу 28.3 сая төгрөгөөр, талх үйлдвэрлэлт 26.0 хувиар буюу 5.6 сая төгрөгөөр тус тус өссөн бол, дулаан дамжуулалт 6.3 хувиар буюу 104.7 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 5. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, тонн



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД: 2013 оны 4 сарын байдлаар дүүрэгт ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 374 байгаа нь энэ оны өмнөх сараас 4.8 хувиар буюу 17 хүнээр, эмэгтэй ажилгүй иргэн 207 байгаа нь өмнөх сараас 4.0 хувиар буюу 8 хүнээр тус тус өссөн байна. Тайлант сард ажил идэвхтэй хайж байгаа 146 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүний 57.7 хувь нь буюу 82 нь эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд энэ сард 6 иргэн ажилд зуучлуулан орж, 123 иргэн бүртгэлээс хасагдсан байна.




Бүртгэлтэй ажилгүй иргэдийн ажилд орсон байдлыг авч үзэхэд:

- төсөвт, төрийн байгууллага – 2
- хувьцаат компани – 1
- хязгаарлагдмал хариуцлагатай компани – 3 хүмүүс тус тус ажилд орсон байна.

2013 оны 4 сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны ангиллаар авч үзэхэд 21.4 хувь нь 16-24 насны, 36.4 хувь нь 25-34 насны, 26.2 хувь нь 35-44 насны, 16.0 хувь нь 45-60 насны ажилгүйчүүд эзэлж байна.

Зураг 7. Бүртгэлтэй ажилгүй иргэн /насны бүлгээр/



Зураг 8. Ажилгүй иргэд боловсролын түвшингээр



2013 оны 4 сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа ажилгүйчүүдыг боловсролын түвшингээр ангилж үзэхэд 23.0 хувийг дээд, 7.2 хувийг тусгай дунд, 6.1 хувийг мэргэжлийн анхан шатны, 52.7 хувийг бүрэн дунд, 7.2 хувийг бүрэн бус дунд, 1.3 хувийг бага боловсролтой, 0.5 хувийг боловсролгүй ажилгүйчүүд тус тус эзэлж байна.

НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ: 2013 оны эхний 4 сарын байдлаар нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын нийт орлого 415.6 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.9 хувиар буюу 16.8 сая төгрөгөөр буурсан байна.

Мөн нийт орлогын 302.1 сая төгрөг буюу 72.7 хувь нь хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 6. Орон сууц нийтийн аж ахуйн орлого зарлагын байдал мянган төгрөг

Үзүүлэлт	2012 он	2013 он	Өөрчлөлт
Орон сууц	116928.0	119394.3	2466.3
Ус борлуулалт-бүгд	158677.9	149116.1	-9561.8
үүнээс: хүн амд	98421.9	92944.6	-5477.3
аж ахуйн нэгжид	57678.1	53687.2	-3990.9
үйлчилгээний байгууллагад	2577.9	2484.3	-93.6
Сувагжуулалт	144334.0	137304.1	-7029.9
Бусад	12533.9	9796.8	-2737.1
Дүн	432473.8	415611.3	-16862.5

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО: 2013 оны эхний 4 сарын байдлаар дүүргийн СӨХ-дын орлогын төлөвлөгөөний биелэлт доорх байдалтай байна.

Хүснэгт 7. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын байдал мянган төгрөг


Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
Тавлаг өргөө	15575.2	15873.5	101.9
Маргад өргөө	12760	13662.2	107.1
Сод хөгжил	16253.8	18413.3	113.3
Шинэ элч	12587.2	13908.6	110.5
Уурхайчин	14336	12862.4	89.7
НИЙТ ДҮН	71512.2	74720	104.5

НИЙГМИЙН ДААТГАЛ: 2013 оны эхний 4 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 2719.7 сая төгрөгт, зарлага 4487.7 сая төгрөгт хүрсэн ба орлого нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 19.6 хувиар буюу 445.3 сая төгрөгөөр, зарлага нь 37.4 хувиар буюу 1221.1 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 62.8 хувь буюу 1708.0 сая төгрөгийг тэтгэвэрийн сангаас, 7.0 хувь буюу 190.8 сая төгрөгийг тэтгэмжийн сангаас, 1.7 хувь буюу 46.6 сая төгрөгийг ажилгүйдлийн сангаас, 8.2 хувь буюу 221.8 сая төгрөгийг ҮОМШӨ сангаас, 20.3 хувь буюу 552.5 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас төвлөрсөн байна.

Хүснэгт 8. Нийгмийн даатгалын сан

Үзүүлэлт	Гүйцэтгэл			
	2012 он		2013 он	
	Хүний тоо	Сая төгрөг	Хүний тоо	Сая төгрөг
Сангийн орлого		2274.4		2719.7
үүнээс: тэтгэвэрийн сан		1440.8		1708.0
тэтгэмжийн сан		104.4		190.8
ажилгүйдлийн сан		101.4		46.6
ҮОМШӨ-ний сан		170.7		221.8
ЭМД-ын сан		457.1		552.5
Сангийн зарлага	32264	3266.6	31652	4487.7
үүнээс: тэтгэвэрийн сан	3114	2009.4	3247	2949.5
тэтгэмжийн сан	814	129.5	899	172.6
ажилгүйдлийн сан	113	104.1	192	53.6
ҮОМШӨ-ний сан	574	448.6	572	582.5
ЭМД-ын сан	27649	575.0	26742	729.5



Нийт зарлагыг бүтцээр авч үзвэл 3247 хүнд 2949.5 сая төгрөгийн тэтгэвэр, 899 хүнд 172.6 сая төгрөгийн тэтгэмж, 572 хүнд 582.5 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 26742 хүнд 729.5 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгал, 192 хүнд 53.6 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна.


НИЙГМИЙН ХАЛАМЖ: 2013 оны эхний 4 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн 68.6 хувь нь орон нутгийн төсвөөс, 29.2 хувь нь улсын төсвөөс, 2.2 хувь нь “Хүний хөгжил” сан болон бусад орлогоор санхүүжигдсэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжинд нийт 842.4 сая төгрөг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 73.3 хувиар буюу 2316.6 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант хугацаанд 544 хүнд 212.7 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 349 хүнд 130.8 сая төгрөгийн тэтгэмж, 890 жирэмсэн эхэд 124.8 сая төгрөг, “Алдарт эх”-ийн одонтой 1931 эхчүүдэд 267.1 сая төгрөг, 1592 ахмад настанд 29.0 сая төгрөгийн хөнгөлөлт, 48 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 21.5 сая төгрөгийн хөнгөлөлт, 22 ахмад дайчинд 15.5 сая төгрөгийн нэмэгдэл, олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 257 хүнд 1.6 сая төгрөг, хүний хөгжил сангаас 25 хүнд 21.8 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Хүснэгт 9. Нийгмийн халамжийн сан


Үзүүлэлт	Гүйцэтгэл			
	2012 он		2013 он	
	Мян төг	Хүний тоо	Мян төг	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого	2675804.3		819369.8	
үүнээс улсын төсвөөс	291378.9		239200.0	
орон нутгийн төсвөөс	4000.0		562457.8	
Хүний хөгжил сангийн санхүүжилт	1900000.0		15000.0	
бусад орлого	480425.4		2712.0	
Нийгмийн халамжийн сангийн зарлага	3158984.0		842391.7	
үүнээс:Тэтгэвэр	128816.4	491	212766.8	544
Тэтгэмж	78322.3	843	130818.4	349
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	80632.8	756	124808.2	890
“Хүний хөгжил” сан	2427520.7	27442	21801.9	25
"Алдарт эх" 1 одонтой эхчүүд	146180.0	735	148000.0	740
"Алдарт эх" 2 одонтой эхчүүд	118560.0	1172	119100.0	1191
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	31840.6	1629	28960.0	1592
Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	15300.0	22	15473.1	22
ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт	13302.0	31	21481.1	48
ОНО-д түшиглэсэн халамжийн үйлчилгээ			1680.2	257
Бусад үйлчилгээ	118509.2		17502.0	



Зураг 10. Нийт орлого - 819.4 сая төгрөг

ЭРҮҮЛ МЭНД: Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээгээр энэ оны эхний 4 сарын байдлаар дүүрэгт 334 эх амаржиж, 334 хүүхэд төрүүлснээс гадны 78 эх амаржсан байна.

Оны эхний 4 сарын байдлаар 76916 хүн амбульторын үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 5447 хүнээр буюу 6.6 хувиар мөн урьдчилан сэргийлэх үзлэгт 29096 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1722 хүнээр буюу 5.6 хувиар, хэвтэн эмчлүүлсэн хүн 2380 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 57 хүнээр буюу 2.3 хувиар тус тус буурсан байна.



Тайлант хугацаанд халдварт өвчний 229 тохиолдол гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 43 тохиолдлоор буюу 23.1 хувиар өссөн байна. Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 84.1 болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 15.1 продицимилээр өссөн байна.

Хүснэгт 10. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2012 он	2013 он	өсөлт бууралт
Халдварт паразит өвчин	137	131	-6
Хамуу	5	-	-5
Заг хүйтэн	36	42	6
Тэмбүү	19	37	18
Мөөгөнцөр	5	-	-5
Трихомноз	32	24	-8
Сүрьеэ	12	18	6
Кандидоз	28	10	-18
Цочмог халдварт өвчин	49	98	49
Цусан суулга	3	4	1
Гепатит А	28	14	-14
Салхин цэцэг	4	13	9
Гахайн хавдар	11	65	54
Рож	1	-	-1
Гар хөл амны өвчин	2	2	-
Нийт халдварт өвчин	186	229	43

Оны эхний 4 сарын байдлаар халдварт паразит өвчин 131 болж нийт халдварт өвчний 57.2 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 6 тохиолдлоор буюу 4.6 хувиар буурсан байна. Харин цочмог халдварт өвчин 98 байгаа нь нийт халдварт өвчний 42.8 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 49 тохиолдлоор буюу 2 дахин өссөн байна. Гахайн хавдар өвчний 65 тохиолдол бүртгэгдсэн нь цочмог халдварт өвчний 66.3 хувийг эзэлж байна.


ГЭМТ ХЭРЭГ: Энэ оны эхний 4 сарын байдлаар дүүрэгт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо 99 байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар буюу 9 хэргээр буурсан байна. Мөн хэрэг илрүүлэлт 67.9 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 9.0 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Хүснэгт 11. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	Хэргийн тоо		Хэргийн өсөлт	Дүнд эзлэх хувь
	2012 он	2013 он		
Хүн амь	1	1	0	1.0
Хүчин	2	2	0	2.0
Дээрэм	3	4	1	4.0
Танхай	16	4	-12	4.0
ББМГУчруулах	48	44	-4	44.4
Ашиглах	1	2	1	2.0
Хулгай	9	24	15	24.2
<i>үүнээс: малын</i>	<i>2</i>	<i>3</i>	<i>1</i>	<i>12.5*</i>
Булаалт			0	0.0
Залилан	1	3	2	3.0
ХАБЭсрэг	4	5	1	5.1
Гал түймэр			0	0.0
Бусад	23	10	-13	10.1
Бүгд	108	99	-9	100.0
Хэрэг илрүүлэлт	76.9%	67.9%		

*- малын хулгайн хэргийг нийт хулгайн хэрэгт эзлэх хувиар тооцсон.

Зураг 12. Бүртгэгдсэн гэмт хэрэг /сараар/



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн бүтцийг авч үзэхэд дийлэнх хувийг буюу 44.4 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах /ББМГУ/ гэмт хэрэг, 24.2 хувийг хулгайн хэрэг, 5.1 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 8.0 хувийг дээрмийн болон танхайн гэмт хэрэг, 3.0 хувийг залилангийн хэрэг, 2.0 хувийг


ашиглах гэмт хэрэг, 2.0 хувийг хүчингийн хэрэг, 1.0 хувийг хүний амины хэрэг тус тус эзэлж байгаа бол, үлдсэн хувийг бусад хэргүүд эзэлж байна.

Хүснэгт 12. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2012 он		2013 он	
	согтуугаар	гудамж талбайд	согтуугаар	гудамж талбайд
Хүн амь	1			
Хүчин	2			
Дээрэм	2	1	2	2

Танхай	16	3	4	3
ИЭЧЭМЭ	28	9	26	11
Ашиглах				
Хулгай		1	2	2
Булаалт				
Залилан				1
ХАБЭсрэг	2		2	1
Гал түймэр				
Бусад	1	7	3	5
Бүгд	52	21	39	25
Дүнд эзлэх хувь	48.2	19.4	39.4	25.3

Зураг 13. Сogтyугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг



2013 оны эхний 4 сарын байдлаар согтуугаар үйлдсэн гэмт хэргийн тоо 39 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 25.0 хувиар буюу 13 хэргээр буурч, нийт гэмт хэргийн 39.4 хувийг эзэлж байгаа бөгөөд нийт гэмт хэрэгт эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 8.8 пунктээр буурсан үзүүлэлт юм.


Тайлант хугацаанд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 25 бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 19.0 хувиар буюу 4 хэргээр өссөн нь бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 25.3 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 5.9 пунктээр нэмэгдсэн байна.

ҮНЭ ХАНШ: 2013 оны 4-р сарын хүнсний өргөн хэрэглээний 19 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад доорх байдалтай байна.

Хүснэгт 13. Өргөн хэрэглээний барааны дундаж үнэ /4 сарын байдлаар/


Барааны нэр төрөл	Х\н	2010 он	2011 он	2012 он	2013 он	2013% 2012
Гурил /дээд/	кг	600	925	900	1075	119.4
Гурил 1-р зэрэг /алтан тариа/	кг	520	693	750	765	102.0
Гурил 2-р зэрэг /алтан тариа/	кг	500	528	525	575	109.5
Цагаан будаа	кг	1530	1600	1600	1638	102.4
Шар будаа	кг	1060	1850	1550	1438	92.8
Хонины мах	кг	4165	4009	7700	8300	107.8
Үхрийн мах	кг	5050	4430	8013	9250	115.4

Зураг 14. Сogтyугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг




Сүү	л	1000	1033	1063	1288	121.2
Тараг	л	1300	1517	1350	1600	118.5
Цөцгийн тос	кг	3350	2700	3000	3000	100.0
Элсэн чихэр	кг	1600	1600	1625	1600	98.5
Монгол төмс	кг	850	842	888	700	78.8
Монгол байцаа	кг	1100	953	988	1200	121.5
Монгол лууван	кг	830	933	900	800	88.9
Манжин	кг	830	1417	825	1288	156.1
Хятад бөөрөнхий сонгино	кг	1150	944	894	1500	167.8
Монгол сонгино	кг	2000	1500	2500	2958	118.3
Ургамлын тос	ш	2387	2725	2850	3056	107.2
Өндөг	ш	230	225	289	265	91.7

Зураг 15. Нэг кг махны үнэ /жил бүрийн 4 сар/




Зураг 16. "Алтантариа" гурилын үнэ /жил бүрийн 4 сар/




Хүснэгт 14. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2013 оны 4 сарын долоо хоногоор

Хүнсний бараа		х.н	4.05	4.12	4.19	4.26	$\frac{4.26\%}{4.19}$	
"Алтан тариа" гурил	Дээд	кг	1075	1075	1075	1075	100.0	
	I зэрэг	кг	765	765	765	765	100.0	
	II зэрэг	кг	575	575	575	575	100.0	
Будаа	цагаан	кг	1650	1650	1650	1600	97.0	
	шар	кг	1450	1450	1450	1400	96.6	
Хонины мах	ястай	кг	7300	7300	7800	8500	109.0	
	цул	кг	8250	8250	9500	9500	100.0	
Үхрийн мах	ястай	кг	8250	8250	9000	9000	100.0	
	цул	кг	9500	9500	10500	10000	95.2	
Адууны мах, ястай		кг	6500	6500	7000	7000	100.0	
Ямааны мах		кг	5750	5750	6500	7000	107.7	
Элсэн чихэр		кг	1600	1600	1600	1600	100.0	
Сүү		литр	1350	1350	1350	1100	81.5	
Тараг		литр	1600	1600	1600	1600	100.0	
Цэцгийн тос, Орос		кг	3000	3000	3000	3000	100.0	
Байцаа		кг	1200	1200	1200	1200	100.0	
Манжин		кг	1100	1100	1500	1450	96.7	
Төмс	монгол	кг	700	700	700	700	100.0	
Лууван	монгол	кг	800	800	800	800	100.0	
Сонгино	хятад	кг	1500	1500	1500	1500	100.0	
бөөрөнхий	монгол	кг	3000	3000	3000	2833	94.4	
Сармис, булцуу		ш	200	200	200	200	100.0	
Огурцы, хятад		кг	4000	4000	4000	3750	93.8	
Помидор, хятад		кг	4000	4000	4000	4000	100.0	
Ургамлын тос		ш	3075	3075	3075	3000	97.6	
Өндөг		ш	265	265	265	265	100.0	
Талх	буриад	том 900г	ш	1000	1000	1000	1000	100.0
		дунд 700г	ш	900	900	900	900	100.0
	жижиг 500г	ш	750	750	750	750	100.0	
	Есөн шанд	ш	750	750	750	750	100.0	
	Атар талх	ш	800	800	800	816	102.0	

Зураг 17. Монгол төмс /нэг кг/



Зураг 18. Монгол лууван /нэг кг/




Хүснэгт 15. Үйлчилгээний үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Үзүүлэлт	Айл өрх	ААНБ
Дулаан	1 м ³ =341 төг	1м ³ =697 төг
Халуун ус	1 хүн=1924 төг /зун/ 1 хүн=1282 төг /өвөл/	1гкал=41147 төг
Цэвэр ус	1хүн=3243 төг 1м ³ =400 төг /тоолууртай/	1м ³ =590 төг /тоолууртай/ 1м ³ =640 төг /тоолуургүй/
Бохир ус	1хүн=2967 төг 1м ³ =360 төг /тоолууртай/	1м ³ =590 төг /тоолууртай/ 1м ³ =650 төг /тоолуургүй/

Хүснэгт 16. Цахилгааны үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Үзүүлэлт	Орон сууцны хэрэглэгчдэд	Гэр хорооллын хэрэглэгчдэд	ААНБайгууллагуудад
0-150 квт	74 төгрөг	71 төгрөг	88 төгрөг
151-250	79 төгрөг	76 төгрөг	
251-ээс дээш квт	84 төгрөг	81 төгрөг	

Зураг 19. Түлш, шатахууны үнэ: 2013 оны 4 сарын долоо хоногоор



Хүснэгт 17. Түлш, шатахууны үнэ /4 сарын байдлаар/

Шатахууны нэр төрөл	2012 он	2013 он	өөрчлөлт	
			хувь	төгрөгөөр
АИ -76,80	1420	1570	10.6	150
АИ -92,93	1638	1710	4.4	72
Дизель түлш	1820	1840	1.1	20

Түлш шатахууны 2013 оны 4-р сарын дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд литр тутамдаа Аи-80 бензин 10.6 хувиар буюу 150 төгрөгөөр, Аи-92 бензин 4.4 хувиар буюу 72 төгрөгөөр, дизель түлш 1.1 хувиар буюу 20 төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 20. Хот хоорондын зор иг тээврийн үнэ: / УБ-БН, БН-УБ/



МЭДЭЭЛЭЛ



Монгол улсын “Статистикийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, “Хүн амын амьжиргааны түвшинг тогтоох тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 1,5 дахь заалтуудын дагуу тухайн жилд мөрдөх хүн амын амьжиргааны доод түвшинг Үндэсний статистикийн хорооноос шинэчлэн тогтоодог билээ. Үүний дагуу 2013 онд мөрдөх түвшинг Үндэсний статистикийн хорооны даргын 2013.04.09 өдрийн 1/52 тоот тушаалаар баталсан бөгөөд уг хэмжээг 2012.04.10 өдрөөс эхлэн мөрдөж байна.

ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН, сард нэг хүнд ногдохоор, бүс нутгаар, онуудаар,

төгрөгөөр

Бүс	2008		2009	2010	2011	2012	2013
	2008.02.22 №01/37	2008.10.09 №01/130	2009.03.25 №01/35	2010.03.22 №01/47	2011.04.01 01/53	2012.03.26 1/36	2013.04.09 1/52
Баруун	70700	94300	96100	97000	104300	115600	132000
Зүүн	70600	89000	90600	91500	105100	116800	130900
Төв	73100	90800	91200	91700	106600	117500	132400
Хангай	65600	85100	86300	90900	103500	113000	130500
Улаанбаатар	73300	94800	101100	101600	118100	126500	149900

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2013 оны 5 дугаар сарын 8

Утас: 70213719

Web: www.ubstat.mn

Email: bnuurgz@mongol.net